



УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2024 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/142

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 122 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/12 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3.20 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн хяналт, удирдлагын нэгдсэн системд сим карт ашиглах тухай 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 21/03-15 дугаар гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хотын инженерийн дэд бүтцийн газар (М.Балдандорж)-т даалгасугай.

2. Юнител ХХК-ний "M2M SMS" үйлчилгээний зардлыг "Тулга системийн Юнителийн сим карт ашиглах" зардлаас 50,000,000 (тавин сая) төгрөгийг сар бүрийн гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Халиун)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн удирдлагын газар (Н.Отгонбаярт)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Ц.ТӨРХҮҮ

